

## ТАНИЛЦУУЛГА

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

**Нэг.** Монгол Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр тус тус баталж, эдгээр хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхлээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 34 дүгээр тогтоолын Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталсантай холбогдуулан хууль хоорондын давхардал, зөрчлийг арилгах үүднээс холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгаснаас гадна Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1-д “Тогтвортой, хариуцлагатай улс төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална.” гэж, 5.3-т “Хууль заавал хэрэгждэг, хүн бүрд эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтална.” гэж, 5.1.3-т “Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж буй бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ.” гэж, 5.2.11-д “Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах,...” гэж, 5.4.1-д “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ.” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын хариуцлагын тогтолцооны бүрдэл хэсэг болох Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчлийн тухай хууль батлагдсан нь цаашид зөвхөн зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид зааснаар, гэмт хэргийг зөвхөн Эрүүгийн хуульд зааснаар ойлгох хууль салбарын давхардал, хийдэлгүй нэгдсэн систем ажиллах нөхцөлийг бүрдүүлэх алхамын эхлэл байв.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас шинээр аливаа хууль хэлэлцэн батлах бүрт тухайн хуулиар зохицуулсан хориглосон, үүрэг болгосон хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг шинээр зөрчилд тооцон Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид тусгах эсэх асуудлыг тухай бүрт шийдвэрлэх хэрэгцээ шаардлага үүсэх бөгөөд зарим тохиолдолд үүнтэй уялдуулан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах, Эрүүгийн хууль тогтоомжийг практикт хэрэгжихүйц байх нөхцөлийг хангах шаардлага үүсэх юм. Тухайлбал, зөрчил, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг

тоолох зохицуулалтыг уялдуулах, зарим зөрчилтэй уялдуулан гэмт хэргийн шинжийг өөрчлөн найруулах, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн батлахтай зэрэгцэн хэд хэдэн хуулиуд батлагдаж, дагаж мөрдөх хугацааг янз бүрээр тогтсоноос шалтгаалан Зөрчлийн тухай хуульд тусгагдаагүй байгааг тусгах зэрэг хэрэгцээ, шаардлага одоогоор үүсээд байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударгаар шүүлгэх эрхийг хангах асуудлыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн тусгасан.Өнгөрсөн хугацаанд энэхүү хуулийг хэрэгжүүлж ажиллах явцад холбогдох байгууллагууд болон иргэдээс гаргасан санал, хүсэлтээс үзэхэд тус хуульд заасан зарим асуудлыг тодруулах, нарийвчлах хэрэгцээ байна.Нөгөө талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг Улсын Их Хурлаар батлах явцад эхний хэлэлцүүлгээр дэмжигдэж, хуулийн төсөлд тусгагдсан санал, эцсийн хэлэлцүүлгээр дэмжигдэхгүй батлагдсаны улмаас хуульд үүссэн хийдэл, давхардлыг арилгах, мөн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өөрчлөгдөн тусгагдсан заалтад нийцүүлэх шаардлага байна.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тавих хяналтынхаа хүрээнд эрх бүхий байгууллагад нийт 180 удаа шалгалт хийж, 2383 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 113 шаардлага бичиж, биелэлтийг нь хангуулан ажилласан бөгөөд энэ хүрээнд 190 хүний зөрчигдсэн эрхийг сэргээсэн бол эрх бүхий албан тушаалтны шийдвэрт холбогдуулан 97 дүгнэлт бичиж шүүхээр шийдвэрлүүлсэн байна. Прокуророос шүүхэд гаргасан дүгнэлтийн 69 хувь нь эрх бүхий албан тушаалтны оногдуулсан шийтгэлийг хүчингүй болгуулахаар, 31 хувь нь шийдвэрт нь өөрчлөлт оруулах тухай дүгнэлт эзэлж байна.

Үүнээс дүгнэхэд өнөөдөр Монгол Улсад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа эрх бүхий 13.000 орчим албан тушаалтны 60-70% нь хуульч бус бусад салбарын мэргэжилтнүүд<sup>1</sup> байгаа тул зөрчил шалгах зарим тодорхой ажиллагаанд мөрдөх журмыг илүү ойлгомжтой болгох шаардлага тулгарч байна.

Тухайлбал, Мэргэжлийн хяналтын байцаагчийн шалган шийдвэрлэх зарим зөрчлийг гаалийн байцаагчийн харьяалалд хамруулсан, зөрчил шалгах зарим тодорхой ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар хэрэгжүүлэхээр хуульчилсан нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээтэй зөрчилдөж байгаа, мөн прокурор эрх бүхий албан тушаалтны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг хянаад гаргах шийдвэрийн хэлбэр, хойшлуулшгүй тохиолдолд явуулсан ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэх болон зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шийдвэрийг хэрхэн зөвтгүүлэх талаархи зохицуулалт тодорхойгүй зэрэг асуудал байна.

Мөн 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Төрийн болон албаны нууцын тухай хуулиар өмнө төрийн нууцад хамаарч байсан мэдээллийг” төрийн болон албаны” хэмээн ангилж, тэдгээрийг хамгаалах журмыг шинэчлэн тогтоосон тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд “төрийн нууц”

---

<sup>1</sup> Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн судалгаа. 2016 он.

гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь зөрчил шалгах ажиллагааны явцад тогтоох хамгаалалт нь зөвхөн төрийн нууцын ангилалд хамаарахаар болсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 6 дугаар сарын 9-ний өдөр батлагдаж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох, хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр заавал биелэгддэг байх зарчмыг бодитой хэрэгжүүлэх, иргэний зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх механизмыг боловсронгуй болгох зорилго бүхий зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүд тусгалаа олсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас тус хуулийг сурталчлах, иргэд, алба хаагчдад хуулийн шинэлэг зохицуулалт, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замын талаар сургалт хийх ажлыг идэвхитэй зохион байгуулж, хуультай уялдуулан дагаж гарах дүрэм, журам, заавруудыг хуульд нийцүүлэн боловсруулж, батлуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн хууль өөрөө цаг үе, нийгмийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн, аливаа зөрчил, давхардал, хийдэлгүй байх нийтлэг зарчимд тулгуурлан Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлгох, хууль ёсны зарчимд илүү нийцүүлэх, практикт хэрэгжихүйц байх нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэр тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагаж гарах бусад хуулийн төслийг боловсруулж, дараахь нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар тусгалаа. Үүнд:

### **Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:**

1. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг зөрчлийн хугацаа тоолох зохицуулалттай уялдуулж, улмаар зарим гэмт хэрэг зэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг боловсронгуй болгохоор өөрчилсөн.

2. Гэмт хэргийн хохирол, хор уршгийн ойлголтын хуульд уялдаа холбоотой байхаар зохицуулсан.

3. Аргагүй хамгаалалтын зохицуулалтанд хамрах хүрээг өргөжүүлсэн.

4. Эрх хасах, хорих зэрэг зарим ялын хэмжээтэй холбоотой зохицуулалтын зөрчлийг арилгасан.

5. Гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалтыг хууль ёс, тэгш эрхийн зарчимд нийцүүлсэн.

6. Шүүхийн практикт хуулийг хэрэглэхтэй холбоотой гарч байгаа хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах, үргэлжилсэн гэмт хэргийн зохицуулалтыг практикт нэг мөр хэрэгжихүйц байдлаар нарийвчлан тусгасан.

7.Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан зарим төрлийн албадлагын арга хэмжээг практикт хэрэглэхтэй холбогдуулан зохицуулалтыг боловсронгуй болгосон.

8.Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэгт оногдуулах ялыг ерөнхий анги болон тусгай ангид заасан бусад ялтай уялдуулан тусгасан.

9.Зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, бэлгийн дарамт учруулах, гүтгэх зэрэг гэмт хэргийг тусгаж, зарим гэмт хэргийн шинжийг ерөнхий ангид заасан нэр томъёотой нийцүүлсэн.

10.Бусад улс оронд нийтлэг хэрэглэгдэж тогтсон зарим ач холбогдолтой зохицуулалтыг Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгасан асуудлыг, жишээлбэл, байнга гэмт хэрэг үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэх зэрэг ойлголт нь практикт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа, эдгээр ойлголтыг практикт хэвшүүлэхэд нилээдгүй цаг хугацаа шаардагдахаар байгааг харгалзан хуульд өөрчлөлт оруулсан.

11.Зарим хуулийн болон хууль сахиулах байгууллагуудаас хуулийг хэрэглэхтэй холбогдуулан тодорхой болгох шаардлагатай зарим асуудлыг хуульд тусгах зэрэг арга хэмжээг авсан.

#### **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:**

1.Шүүх хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүгч нэмж оруулах болон бүрэлдэхүүнгүй болсон тохиолдолд хэрхэн шийдвэрлэхийг ялгаж тусгайлан зохицуулсан.

2.Мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах үүднээс прокурорын даалгаварт мөрдөгч санал бичих, мөн зарим тохиолдолд мөрдөгч даавгавар бичих эрхтэй байхаар заасан.

3.Мэдүүлэг авах тухай бүлэгт үндсэн шаардлага болон тусгагдсан боловч зарим нэг оролцогчийн эрхэд тусгагдаагүй асуудлыг тухайлан тусгасан.

4.Практикт хэрэгжүүлэх явцад анхан шатны шүүхэд шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулах зэрэг асуудал гарч байгааг шийдвэрлэх зорилгоор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуулиар харьяалуулсан асуудлыг шийдвэрлэсэн шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахаар өөрчилсөн.

5.Гэмт хэрэгт холбогдож байгаа хүмүүсийн ихэнх нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй байгааг харгалзан таслан сэргийлэх зарим арга хэмжээнд өөрчлөлт оруулсан.

6.Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох зүйлд Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу өөрчлөлт оруулсан.

7.Мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах зорилгоор хуульд тогтоосон зарим хугацаа нь практикт тухайн ажиллагааг явуулж багтахгүй байгаа саналыг харгалзан хугацааг сунгах зохицуулалт оруулсан.

8.Хуульд ерөнхий заасан зарим асуудлыг нарийвчлан тусгасан.Тухайлбал, яллагдагч яллах дүгнэлтийг хүлээн авахгүй тохиолдолд хийх ажиллагаа, яллагдагчаар татах тогтоолд өөрчлөлт орсон тохиолдолд хийх ажиллагаа зэрэг.

9.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд орсон гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаархи өөрчлөлтөд нийцүүлэн хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай зохицуулалтад өөрчлөлт оруулсан.

10.Анхан, давах, хяналтын шатны шүүхийн шийдвэртэй холбоотой зохицуулалтад өөрчлөлт оруулсан.

11.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль бус ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэлд өөрчлөлт оруулсан.

### **Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:**

1.Усан замын тээврийн тухай хууль зөрчих зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 14 дүгээр бүлэгт тусгасан.

2. Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчих зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 15 дугаар бүлэгт тусгасан.

3.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль зөрчих зөрчлийг өөрчлөн найруулсан;

4.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль зөрчих зөрчих зөрчлийг нэмсэн;

5.Хог хаягдлын тухай хууль зөрчих зөрчлийг шинээр батлагдсан хуультай нийцүүлэх өөрчлөн найруулсан;

6.Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих зөрчлийн давхардлыг арилгаж өөрчлөн найруулсан;

7.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар зохицуулагдаагүй аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж болон Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн захиргааны хэм хэмжээний акт гаргах талаар тусган холбогдох зөрчлийг хуульд тусгасан;

8.Биеийн тамир, спортын тухай хууль батлагдсантай холбогдуулан зөрчлийг тусгасан;

9.Бусад хууль, эрх зүйн актуудтай холбогдуулан нийцүүлэх шаардлагатай, практикт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэсэн зохицуулалтуулыг хэрэгжихүйц байдлаар өөрчлөн найруулсан. Тухайлбал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад заасан

зарим гэмт хэрэгтэй уялдуулан шинээр зөрчлийг томъёолох зэргээр хуулиудын уялдаа холбоог хангасан.

**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:**

1.Хуулийн 1.8 дугаар зүйийн 6 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан, шүүхийн зөрчил шалган шийдвэрлэх харьяаллын давхардал, хийдлийг арилгасан.

2.Зөрчил шалгах зарим ажиллагааг явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлэхээр зохицуулсан нь давхардал, хийдлээс гадна салбарын хүрээнд тус хуулийг хэрэгжүүлж байгаа улсын байцаагчдын дунд ойлголтын зөрүү бий болох зэргээр бэрхшээл үүсгэж байгааг өөрчилж, нэгтгэн зохицуулсан.

3.Прокурор зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хянаад гаргах шийдвэр, түүний журам, түүнчлэн зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаад эрх бүхий албан тушаалтнаас гаргах шийдвэрийн нэг хэлбэр болох зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэлээс чөлөөлөх шийдвэр гаргах ажиллагааны журмыг тодорхой тогтоосон.

4.Хялбаршуулсан журмаар зөрчил шийдвэрлэх ажиллагааны журам болон шийдвэрт гомдол гаргах журмыг тодорхой зохицуулсан.

5.Зөрчил үйлдсэн этгээдийг донтох сэтгэцийн эмгэгтэй эсэхийг тогтоох шинжилгээ хийх, шүүхээс албадан эмчилгээнд хамруулах шийдвэр гаргах журам болон хэрэгжүүлэх ажиллагаатай холбоотой журмыг нарийвчлан зохицуулсан.

6.Тусгай журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахаар заасан баривчлах шийтгэл бүхий зөрчлийг шалгах ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор холбогдогчийг дуудан ирүүлэх, зөрчлийн хэргийг нэгтгэх, тусгаарлах журмыг хуульд шинээр нэмж зохицуулсан.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд:**

Хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд иргэд, төрийн болон төрийн бус байгууллагаас тус хуулийн зарим зүйл, хэсэг, тэдгээрт туссан зохицуулалтууд хоорондын зөрчил, давхардал, хийдэлтэй холбоотой зарчмын шинжтэй санал төдийлэн гараагүй боловч иргэдээс тус хуулийн зарим зохицуулалт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулахаар Үндсэн хуулийн цэцэд хандсан тохиолдлууд нилээдгүй гарсан. Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хуулийн зөрчил, давхардал, хийдлийг арилгах талаар тодорхой саналууд ирүүлснийг судалж, хуулийн төсөлд тусгав.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар эдгээр хуулийн төслүүдийг санаачлан боловсруулсан тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн 12.2.24 дэх заалтад заасны дагуу мөн хуулийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалыг баримтлаагүй болно.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэр тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэн боловсруулсан ба хуулийн төсөл батлагдсанаар төсөвт ачаалал үүсэхгүй, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсэхгүй.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хууль тогтоомжийн төсөл боловсруулсан.

## **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**